

МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЧЛОЛ

№ 14/2

Улаанбаатар хот

Мөнгөний бодлогын зөвлөл (МБЗ) нь 2014 оны 4 дүгээр сарын 24, 5 дугаар сарын 21 болон 7 дугаар сарын 30-ны өдрүүдэд нийт 3 удаа хуралдсан бөгөөд хурлыг Монголбанкны Ерөнхийлөгч Н.Золжаргал удирдан явуулав.

2013 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр МБЗ нь Монголбанкны Мөнгөний бодлого, судалгааны газар (МБСГ)-аас танилцуулсан макро эдийн засгийн өнөөгийн болон ойрын ирээдүйн төлвийн талаарх дараах асуудлуудыг авч хэлэлцэв.

Хэдийгээр 2014, 2015 онд АНУ, Евро бүс, Япон зэрэг хөгжингүй орнуудын эдийн засгийн өсөлт сэргэх төлөвтэй байгаа ч түүхий эдийн гол хэрэглэгч Хятад улсын Засгийн газар хөрөнгө оруулалтаа хумьж, хувийн хэрэглээнд тулгуурласан өсөлтийг бий болгох бодлого хэрэгжүүлж байгаагийн улмаас дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ ирэх 2 жилд төдийлөн сайжрахааргүй байна. Түүнчлэн Австрали улсаас экспортолж буй нүүрсний үнэтэй харьцуулахад манай улсын нүүрсний үнийн өрсөлдөх чадвар муу хэвээр байгаа зэргээс шалтгаалан манай улсын гадаад худалдааны нөхцөл үргэлжлэн муудахаар байна.

2014 онд эдийн засгийн жилийн өсөлт өмнөх онтой харьцуулахад буурахаар хүлээгдэж байгаа бөгөөд гол шалтгаан нь уул уурхайн өсөлт болон гадаад үнэ өмнө төсөөлж байснаас илүү багассан явдал байв. Өнгөрсөн онд хэрэгжүүлсэн уламжлалт болон уламжлалт бус мөнгөний тэлэх бодлого нь үйлдвэрлэлийн зөрүүд эерэгээр нөлөөлж буй хэдий ч гадаад эрэлт, гадаадын шууд хөрөнгө оруулалт эрс буурч, нүүрсний экспортын өрсөлдөх чадвар муудсанаар үйлдвэрлэлийн зөрүү өмнөх оны сүүлийн улирлаас эхлэн сөрөг утгатай болж, энэ төлөв цаашид ч үргэлжлэхээр байна. Эдийн засгийн идэвхжил төсөөлж байснаас илүү суларч, татварын орлого буурч, тухайлбал нэмэгдсэн өртгийн албан татвар төлөвлөснөөс огцом буурсан нь төсвийн орлого тасалдах шалтгаан болж, цаашид улам ихсэхээр байгаа нь төсвийн зардлыг бууруулахад хүргэхээр байна. Эдийн засгийн нөхцөл байдал цаашид сайжрахгүй тохиолдолд төсвийн орлого улам их хэмжээгээр тасрах магадлалтай байна.

Төлбөрийн тэнцлийн урсгал данс алдагдалтай хэвээр, түүнийг нөхөх хэмжээний ашиг хөрөнгө санхүүгийн данснаас бий болохооргүй байгаа нь оны эцэст төлбөрийн тэнцэл алдагдалтай хэвээр, гадаад валютын нөөцөд дарамт үзүүлэхээр байна. Гадаад цэвэр актив ийнхүү буурч, үүнийг дотоод цэвэр активаар нөхөх боломж хязгаарлагдмал байгаа нь оны сүүл рүү мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг бууруулахаар байна.

Суурь төсөөллийн дагуу эдийн засгийн өсөлтийн хурд хэдийгээр буурч байгаа боловч инфляци өсч, гадаад худалдааны нөхцөл сайжрахгүй байгаа нь төлбөрийн тэнцлийн алдагдлыг нэмэгдүүлж, ханш сулрах дарамт үргэлжлэн өссөнөөр гадаад валютын улсын нөөцийг ахин бууруулах, улмаар санхүүгийн салбарын эрсдэл өсч болзошгүй байгаа нь Монголбанк Бодлогын хүүг өсгөх шаардлагыг бий болгож байна.

МБСГ-ын зүгээс Бодлогын хүүг тодорхой нэгж хувиар өсгөх, мөн Засгийн газартай хамтран хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийн хүрээнд энэ онд нэмж зээл гаргахгүй, батлагдсан хуваарийн дагуу зээлийг эргэн төлүүлэх саналыг хурлаар танилцуулсан.

Монголбанкны МБЗ-ийн дараагийн хурал 2014 оны 5 дугаар сарын 21-ний өдөр боллоо. Энэхүү хурал нь МБЗ-ийн 2014 оны 4 дүгээр сарын хурлын 2 дахь удаагийн хурал бөгөөд 2014 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр товлосон байсан боловч хойшлогдоод байсан юм. Учир нь эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор УИХ-аас “Эдийн засгийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” 34 дүгээр тогтоолыг 5 дугаар сарын 8-ны өдөр баталсан. Үүнтэй холбоотойгоор МБСГ дээрх тогтоолын арга хэмжээ, холбогдох тооцооллыг мөнгөний бодлогын саналд тусгах, дахин боловсруулах шаардлагатай болсон бөгөөд тус газраас инфляцийн болон ханш сулрах дарамтыг бууруулж, төгрөгийн өгөөжийг нэмэгдүүлэн гадаад валютын дотогшлох урсгалыг дэмжих зорилгоор Бодлогын хүүг өсгөх саналыг танилцуулсан.

Хурлаар УИХ-ын 34-р тогтоолын хүрээнд 2014 онд макро эдийн засаг, төсвийн бодлогод ямар өөрчлөлт, үр дүн гарах, мөнгөний бодлогыг үүнтэй хэрхэн уялдуулах талаар хэлэлцсэн. Тухайлбал, тогтоолд тусгасан арга хэмжээ болох төсвийн урсгал зардлыг 20 хувиар бууруулах нь хэр бодитой байх, Монгол Улсын Хөгжлийн банкны зарцуулалт буюу төсөвтэй адилтгах зардлыг төсвийн тооцоонд тусгах эсэх нь тодорхой бус байгааг зөвлөлийн гишүүд онцолж байлаа. Монгол Улсын 2013 оны төсвийн алдагдал ДНБ-ий 1.7 хувьтай тэнцүү гарсан хэдий ч төсөвтэй адилтгах зардлыг оруулж тооцсоноор төсвийн алдагдал ДНБ-ий 11.2 хувьтай тэнцэж байна. Хэрэв төсвөөс гадуурх зарцуулалтыг улсын төсөвт оруулж тооцохгүй бол энэ хандлага 2014 онд ч хэвээр үргэлжлэхээр байгаа юм.

Мөн тогтоолд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлснээр манай улсад 2014 онд орж ирэх гадаад валютын урсгал хэрхэн нэмэгдэх, төлбөрийн тэнцэлд ямар эерэг нөлөө үзүүлэхийг тооцоолоход хүндрэлтэй, олон асуудал тодорхой бус байна. Дээрх тодорхой бус байдлыг арилгах зорилгоор Засгийн газрын зүгээс тодорхой арга хэмжээ авах, холбогдох хууль тогтоомжийг яаралтай өргөн барих шаардлага үүсээд байгаа талаар зөвлөлийн гишүүд санал нэгдэж байлаа.

Ийнхүү МБЗ мөнгөний бодлогын санал болон эдийн засагт тулгараад буй асуудлыг тал бүрээс нь нухацтай хэлэлцсэний үр дүнд дээрх тодорхой бус байдал арилах, ялангуяа төсвийн бодлого, төсөвт хийх тодотголын бодит хэмжээ, төсвөөс гадуурх зарцуулалтын шинэ зохицуулалтууд нь илүү тодорхой болсон нөхцөлд шийдвэр гаргахаар тогтлоо.

МБЗ-ийн 7 дугаар сарын 30-ны өдрийн хурлаар МБСГ-ын зүгээс макро эдийн засгийн өнөөгийн болон ойрын төлвийн талаарх танилцуулгыг шинэчлэн гишүүдэд хүргэсэн бөгөөд Бодлогын хүүг 2014 онд нийт 2.5 нэгж хувиар өсгөх, энэ удаа 1.5 нэгж хувиар өсгөх, мөн Засгийн газартай хамтран хэрэгжүүлж буй үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд энэ онд дахин санхүүжилт гаргахгүй, батлагдсан хуваарийн дагуу хөтөлбөрийн зээлийг эргэн төлүүлэх саналыг хурлаар дахин танилцуулсан. Үндэсний статистикийн хорооны мэдээгээр хэрэглээний үнийн индексээр илэрхийлсэн инфляци 2014 оны 6 дугаар сарын эцэст улсын хэмжээнд жилийн 14.6 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 15.1 хувьд хүрсэн байна. 2014 оны эхний хагас жилийн байдлаар төлбөрийн тэнцлийн алдагдал 915.1 сая ам.доллар, төсвийн орлого төлөвлөгөөнөөс 400 тэрбум төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй бөгөөд төсвийн алдагдал 241 тэрбум төгрөгт хүрч нэмэгдээд байна.

Засгийн газар болон Төв банкнаас хамтран хэрэгжүүлсэн гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөрүүдийн нөлөөгөөр инфляцийн бүтэц дэх нийлүүлэлтийн

сөрөг хүчин зүйлсийн нөлөө буурч байгаа ч, төлбөрийн тэнцлийн алдагдал, төсөв, төсөвтэй адилтгах зардал болон зээлийн өсөлт, төгрөгийн ханшийн сулралт зэрэг нь цаашдын инфляцийн өрнөлийг хурдасгах, төлбөрийн тэнцлийн хүндрэлийг улам даамжруулах эрсдэлтэй байна. Мөн олон улсын зах дээр манай улс мөнгөний бодлогоо тогтвортой байдал уруу эргүүлж, дорвитой өөрчлөлт хийхийг хүлээж, харж байгаа. Тиймээс Бодлогын хүүг огцом өсгөх саналыг танилцуулж байгаа болохыг МБСГ-ын зүгээс тайлбарласан.

Ийнхүү бодлогын саналыг танилцуулсны дараа МБЗ-ийн гишүүд өргөн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүллээ. Юуны түрүүнд зарим гишүүд, Бодлогын хүүг өсгөх нь инфляцийг бууруулах нөлөө үзүүлэх ч, эдийн засагт мөнгөний нийлүүлэлт, зээлийг бууруулж, улмаар бодит үйлдвэрлэл, дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг саармагжуулах сул талтай болохыг анхааруулсан. Түүнчлэн үнэ тогтворжуулах хөтөлбөрийн зээлийн үлдэгдлийг 2014 онд тодорхой дүнгээр бууруулж байгаа хэдий ч, энэ нь банкны салбарт бага хэмжээтэй тул эдийн засагт үзүүлэх нөлөөнд эргэлзэж байлаа. Хэрэв гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэж, их хэмжээний валют ороод ирсэн тохиолдолд манай улсын төлбөрийн тэнцлийн алдагдлыг бууруулах боломжтой, тэр хэрээр санхүүгийн салбар дахь эрсдэл буурах, эдийн засгийн хүндрэл багасах, инфляцийн дарамт буурах бололцоо бүрдэнэ хэмээн гишүүд зөвлөж байлаа.

Бодлогын хүүг өсгөснөөр дотоод эрэлтийг хязгаарлаж, гадаад худалдааны алдагдлыг бууруулахаас гадна, төгрөгийн харьцангуй өгөөжийг нэмэгдүүлж төгрөг сулрах дарамтыг багасгана. Ийнхүү нийт эрэлт буурч, ханш сулрах дарамт багасахын хэрээр инфляци яваандаа буурч зорилтот түвшинд илүү хурдан хүрэх боломжийг олгох юм. Энэхүү бодлогын шийдвэр нь макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн төсөөллийг сайжруулж байгаагийн зэрэгцээ эрсдэлийг ихээр бууруулах болно гэдэгт гишүүд санал нэгдэж байлаа.

Монголбанк, Засгийн газрын хамтран хэрэгжүүлж буй “Үнэ тогтворжуулах хөтөлбөр”-ийн зээлийн хэмжээг бууруулснаар мөнгөний тэлсэн бодлогыг багасгана. Гэхдээ банкны систем нь өөрөө мөнгө үржүүлэгчийн үүрэг гүйцэтгэдэг тул бага мөнгө байсан ч үржиж өсөх болно гэдгийг гишүүд анхааруулж байлаа. Харин гаднаас огцом их хэмжээний валют орж ирвэл цааш хэрхэн зарцуулагдах вэ гэдгээс шалтгаална. Хэрэв бид орж ирсэн гадаад валютыг төгрөг болгоод буцаад эдийн засагтаа нийлүүлээд байвал эрэлтийг нэмэгдүүлж, эрэлтийн талын инфляцийн дарамтыг нэмэгдүүлнэ, харин импортыг санхүүжүүлэх юм бол ямар ч эерэг нөлөөгүй байх болно гэдгийг онцолсон.

Ийнхүү МБЗ-ийн гишүүд мөнгөний бодлогын саналыг тал бүрээс нь авч үзэн, өргөн хүрээнд хэлэлцүүлэг хийсний дүнд, эдийн засгийн өсөлтийн хурд хэдийгээр буурч байгаа боловч инфляци өсч, гадаад худалдааны нөхцөл сайжрахгүй байгаа нь төлбөрийн тэнцлийн алдагдлыг нэмэгдүүлж, ханш сулрах дарамт үргэлжлэн өссөнөөр гадаад валютын улсын нөөцийг үргэлжлүүлэн бууруулах, улмаар төлбөрийн тэнцлийн хүндрэл нь санхүүгийн салбарт сөрөг нөлөөлөл бий болгох эрсдэлтэй байгаа, манай улсын эдийн засгийн нэр хүнд гадаад зах зээлд унаж байгаа зэрэг нь Монголбанк Бодлогын хүүг өсгөх шаардлагыг бий болгож байна гэдэгт санал нэгдлээ. Хурлыг удирдагч Бодлогын хүүг хэдэн нэгж хувиар өсгөх талаар санал хураахад, МБЗ-ийн олонхи гишүүд Бодлогын хүүг 1.5 нэгж хувиар өсгөх саналыг дэмжив.

Иймд, Монголбанк төлбөрийн тэнцлийн хүндрэлийг зөөлрүүлэх, инфляцийг эрчимжүүлэхгүй байлгах, дунд болон урт хугацаанд санхүүгийн тогтвортой байдлыг хангах, макро эдийн засгийн тогтвортой байдалд учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх, иргэдийн бодит орлогыг хамгаалах зорилгоор төгрөгийн өгөөжийг нэмэгдүүлсэн мөнгөний бодлогыг чангаруулах арга хэмжээ авч байна. Гэхдээ бодлогын уг арга хэмжээ нь Чингис болон Самурай бондын эх үүсвэрийн хүрээнд Монгол Улсын Хөгжлийн банкнаас хийж буй хөрөнгө оруулалтыг нэгтгэн тооцсон нэгдсэн төсвийн зохистой бодлоготой хамт хэрэгжих ёстой гэдэг дээр МБЗ-ийн гишүүд санал нэгдэв.

Төлбөрийн тэнцлийн дарамтыг арилгаж, эдийн засгийг хүндрэлээс гаргахын тулд төсвийн тогтвортой байдлыг хангаж, экспортын орлого, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар гадаад валютын орох урсгалыг эрс сайжруулах нь чухал хэвээр байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Монголбанкны МБЗ-ийн 2014 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн хурлаар Бодлогын хүүг 1.5 нэгж хувиар нэмэгдүүлж, 12.0 хувь болгох шийдвэр гаргав.